



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 11 сарын 13 едэр

Дугаар 05

Улаанбаатар хот

Хилийн боомтоор тээвэрлэлт хийх үеийн  
халдварт, хамгааллын арга хэмжээг  
эрчимжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтооолын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, Дорнод, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд аймгийн Засаг дарга наарт тус тус ДААЛГАХ Нь:

Нэг: Хилийн боомтын халдварт хамгааллын дэглэмийг эрчимжүүлэх.

1.1 "Хилийн авто замын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах тур журам"-н дагуу тусгаарлалтын бүс байгуулж, халдварт хамгааллын дэглэмийг сахиулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

1.2. Хилийн хяналтыг сайжруулж, тандалт судалгааг эрчимжүүлэх;

1.3. БНХАУ-аас импортолж буй түргэн гэмтэх, муудах бараа, бутзэгдэхүүнээс бусад ачаа барааг зөвхөн төмөр замаар тээвэрлэх, БНХАУ-ын Эрээн өртөөнд автомшинаас төмөр зам руу шилжүүлэн ачих арга хэмжээ авахыг Хятадын талтай хэлэлцэн шийдвэрлэх;

1.4. Экспортын ашигт малтмалын улс хоорондын тээвэрлэлт хийдэг аж ахуйн нэгжийн удирдлагуудын дотоодод тавих хяналтыг чангатгах, тээврийн хэрэгсэл, ачаа тээшийг ариутгаж, халдварт гүйцэтгэх үйл ажиллагааг шаардлага хангасан нөхцөлд стандартын дагуу хийх;

1.5. Гашуунсухайт, Шивээхүрэн, Замын-Үүд боомтоор нүүрсний экспортын тээвэрлэлт гүйцэтгэж буй жолооч нарыг халдвараас хамгаалах тусгаарлалтын дэглэмийг чангатгаж, "Коронавируст халдвартын үед уул уурхайн бутзэгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөлд зохион байгуулах тур журам"-д заасан халдвараас сэргийлэх дэглэмийг чанд мөрдүүлж, дотоодын болон

улс хоорондын тээвэрлэлтэд ажиллаж буй жолооч нарыг хооронд нь харьцуулахгүй байхад хяналт тавьж ажиллах;

1.6. Экспортын ашигт малтмалын улс хоорондын тээвэрлэлт хийдэг аж ахуйн нэгжийн удирдлагуудын дотоодод тавих хяналтыг чангатгах, тээврийн хэрэгсэл, ачаа тээшийг ариутгаж, халдвартгүйжүүлэх үйл ажиллагааг шаардлага хангасан нөхцөлд явуулах;

1.7. Хилийн боомтуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг сайжруулан тээвэр хийж байгаа жолооч нарын зруул мэндэд хяналт тавих;

1.8. Хилийн авто замын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэж байгаа тээврийн компаниуд жолооч нарыг амны хаалт, бээлий, халдвартгүйжүүлэлтийн бодисоор хангах, халдварт хамгааллын дүрэм, журмыг мөрдүүлэх;

1.9. Жолооч нарыг коронавируст халдварт (Covid-19)-ын оношлогооны шинжилгээг түргэвчилсэн болон полимеразын гинжин урвалын /PCR/-ын аргаар Хятадын талд хийсэн шинжилгээтэй дүнтэй уялдуулан хийж, хяналтыг тогтмолжуулах;

Хоёр: Хилийн боомтод ажиллаж байгаа албан хаагчдын ажлын нөхцөлийг сайжруулах.

2.1. Хилийн боомтод ажиллаж байгаа хил, гааль, мэргэжлийн хяналт, эмнэлгийн ажилтнуудыг халдварт, хамгааллын нэг удаагийн хувцас хэрэгслээр бүрэн хангах, хувцас өмсч, тайлах дадлага сургалт тогтмол зохион байгуулах;

2.2. Эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудын зруул мэнд, ариутгал халдвартгүйтгэлийн дэглэм, хөдөлмөрийн аюулгүй байдлыг чанд сахиулах, илүү цагаар ажилласны хөлс, урамшууллыг тооцож олгох;

Гурав. Албан даалгаварын хэрэгжилтийг тайлгаха.

Яам, агентлаг, хилийн боомт бүхий аймгууд албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг нэгтгэн Улсын Онцгой комиссын ажлын албанд 7 хоног бурийн Баасан гарарт цахимаар болон албан бичгээр ирүүлэх;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Я СОДБААТАР